

Ажлын хуудас

1. “Тань руу нүүж явна” киноны аялгууг анхааралтай сонсоорой. Сэдэв аялгууг ноотоор аялаад аль нь болохыг тодорхойлоорой.

“А” хувилбар аялгуу



“Б” хувилбар аялгуу



2. Хөгжмийн зохиолч Н.А.Римский-Корсаковын “Шехеразада” симфони чуулбар хэдэн ангитай вэ?

А. 2 ангитай

Б.5 ангитай

В.4 ангитай

Г.3 ангитай

3. Зураач А.Гартман хөгжмийн зохиолч М.П.Мусоргский нарын нэг сэдвээр туурвисан “Хоёр еврей” хэмээх бүтээлийг хөгжмөөр хэрхэн харьцуулах вэ?



4. Бүжгийн төрлүүдийг зөв харгалзуулаарай.



Ардын
бүжиг

Орчин
үеийн бүжиг

Цэнгээнт
бүжиг

Сонгодог
бүжиг

5. Ч.Лодойдамба “Шаргачин” өгүүллэгээрээ, хөгжмийн зохиолч Б.Мөнхжаргал “Шаргачин” симфоноороо өөр өөрийн санааг хэрхэн илэрхийлснийг хүснэгтэнд бичнэ үү?

Б.Мөнхжаргал

“ШАРГАЧИН” СИМФОНИ



Хаврын хурц нар нэлээд дээр мандаад ойр орчмыг хөхөмдөг манан бүрхэж, өргөн талд байгаа юмс цөм зэрэгтэн жирвэлзэж байлаа. Цайдам хөндийн зүүн зах нь болсон хэсэг дэрс рүү эхээс гарвад хэдхэн хоносон цайвар цагаан янзагаа дагуулсан шаргачин орж ирлээ. Янзага нь тонгочин тоглож орчин тойронд өөрөөс нь өөр юмгүй мэт бүхнийг мартан явахад нь эх нь тал бүр сэрвэлзэн өчүүхэн чимээг ч сэрэмжлэн чагнаж нүдэнд нь торсон бүхнийг «Юу вэ?, Яах гэж байна?» гэсэн бололтой нарийвчлан ажиглаж явлаа.


Уураг нь дуусаагүй өөг сүүндээ гэдэс нь цадсанаас ч юм уу нялх бие нь тоглоомдоо ядарснаас ч юм уу? Аль зуу зуун жилээр үргэлжилсэн хатуу амьдралын сургаал ч юм уу? Бүү мэд. Юу ч гэсэн дэрсэнд орсны дараа удалгүй янзага нь нуугдан унтав.



Цонхоор нь буунууд шоролзон гарсан машин, эзэрийн хойноос байдаг хурдаар довтлон ирлээ. Хурдан хөлдөө гүн итгэсэн шаргачин дүүлж дөрвөн хөл нь газар хүрч байгаа эсэх нь үл мэдэгдэн хурдлав.



Гүйцэгдэхгүй, оногдохгүй байх чинь яагаав? гэж нэг нь хэлээд нөгөө нэг нь шаргачны дэргэд ташаагаа тулж ханхалзан зогсоход тэрийн хэвтэж бүх бие нь үхлийн өмнөх чичрэлтээр татганаж байгаа шаргачин эцсийн хүчээ дайчлан янзагаа нуусан зүг рүү амьдралын оч орхин хаяж байгаа нүдээр харлаа....



Янзага



6. А.Эрдэнэ-Очирийн “Дорноговьруу галт тэрэг хөдлөхөд”

шүлгээр Б.Өлзийбаяр “286 дугаар галт тэрэг” симфони зураглал